



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2025.06.27 № 1979
танай 2025.06.20 -ны № 23 -т

Хариу хүргүүлэх тухай

Таны ирүүлсэн асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдах хууль эрхзүйн зохицуулалтын баримт бичгүүд үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангах чиглэлд цаашид ч анхаарч ажиллаж байна.

Асуулт 1: Хууль батлагдсанаар журам 14, аргачилал, жагсаалт 2, баталгаажуулалтын гэрчилгээ болон дотоод хяналтын хуудасны загвар, мэдээллийн санд хэрэглэгчээр бүртгүүлэх маягтын загвар батлагдсан эсэх, холбогдох тайлбар мэдээлэл;

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д "Хамтын баталгаажилтын байгууллагад тавигдах шаардлага, түүнийг байгуулах, бүртгүүлэх, баталгаажуулалт хийх"; 12 дугаар зүйлийн 12.2-т "Баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, үйлчилгээг мэдээллийн санд бүртгэх"; 15 дугаар зүйлийн 15.2.6-д "Органик салбарын үндэсний зөвлөлийг байгуулах, ажиллах журам"; 15.3-т "Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам", 16 дугаар зүйлийн 16.3-д "Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын журам"-ыг тус тус батлагдахаар заасан.

Нийт батлагдвал зохих 5 журмаас 12.2-т заасан "Баталгаажсан шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүн, үйлчилгээг мэдээллийн санд бүртгэх" журам батлагдсан, 4 журмын төсөл боловсруулагдсан, олон нийт болон холбогдох байгууллагуудаас санал авч, хэлэлцүүлэг хийх ажлууд төлөвлөгдөн хийгдэж байна.

Түүнчлэн, 7 дугаар зүйлийн 7.4-д "Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачилал болон жагсаалт"; 13 дугаар зүйлийн 13.8-д "Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачилал"-ыг тус тус батлахаар хуульчилсан. Тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист тавигдах шаардлага, тэдгээрийг үнэлэх аргачилал болон жагсаалт"-ын төсөл боловсруулагдаж дууссан, 13 дугаар зүйлийн 13.8-д заасан "Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачилал" боловсруулалтын түвшинд байна.

Мөн 13 дугаар зүйлийн 13.1-д "Энэ хуульд заасны дагуу баталгаажуулж, бүртгүүлсэн бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийн загвар", 11 дүгээр зүйлийн 11.6-д "Энэ хуулийн 11.4.2-т заасан баталгаажуулалтын гэрчилгээний загвар" тус тус ХХААХҮ-ийн Сайдын 2024 оны 545 дугаартай тушаалын хавсралтаар шинэчлэн батлагдсан.

Асуулт 2: Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний таван жилд 100 хувиар, дараагийн таван жилд 50 хувиар хөнгөлөх заалтын хэрэгжилтийн талаар;

Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын журмын төсөлд тусгагдсан.

Асуулт 3: ХХААХҮЯ-ны өмчлөлд бүртгэлтэй байгаа органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийн "органик хүнс" гэснийг "органик бүтээгдэхүүн" болгох шийдвэрийн хэрэгжилт;

"Шилжилтийн үеийн болон органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдгийн загвар", "Шилжилтийн үеийн органик болон бүтээгдэхүүнд олгох баталгаажуулалтын гэрчилгээний загвар" нь тус тус ХХААХҮ-ийн Сайдын 2024 оны А/545 дугаартай тушаалаар шинэчлэгдэн батлагдсан.

Асуулт 4: Хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;

Өнөөдрийн байдлаар мэдээллийн сан (organic.gov.mn)-д хүсэлт ирээгүй байна.

Асуулт 5: Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн төлбөр, органик бүтээгдэхүүнийг экспортлоход зориулсан хөрөнгө оруулалтад зориулан арилжааны банкнаас авсан зээлийн 50-иас доошгүй хувийг төрөөс хүүгийн дэмжлэг үзүүлэх, органик бүтээгдэхүүнтэй холбогдох мэдээлэл, сургалт, сурталчилгааг улсын төсвөөс санхүүжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх гарц, механизмыг хэрхэн бүрдүүлж байгаа талаарх судалгаа, мэдээлэл;

Дээрх асуудлууд "Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын журам"-ын төсөлд тусгагдсан ба 3 дугаар улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.

Асуулт 6: Органик хүнсний бүртгэлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар болон органик талбайн талаарх судалгаа, мэдээллийн сан бүрдүүлсэн эсэх;

Мэдээллийн сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд 2025 онд дотоодын 21 органик бүтээгдэхүүн холбогдох журмын дагуу баталгаажуулсан байна. Одоо ашиглаж буй мэдээллийн системийг шинэчлэгдэн батлагдсан хуулийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх шаардлагатай бөгөөд тухайлбал мэдээллийн системийг QR кодын шийдэлтэй холбох, Татварын ерөнхий газар (ebarimt), Гаалийн ерөнхий газар, E-mongolia зэрэг төрийн мэдээллийн системүүдтэй холбон мэдээлэл харилцан солилцдог болгох, органик үйлдвэрлэл эрхлэгчдийн байршил, газрын мэдээллийг системд нэгтгэх, Газар зүйн мэдээллийн систем (GIS)-тэй холбох, гар утасны аппликейшн хөгжүүлэх зэрэг ажлууд төлөвлөгдөн хийгдэх болно.

Асуулт 7: “органик”, “байгалийн цэвэр”, “байгалийн гаралтай цэвэр”, “эко”, “ногоон”, “экологийн гаралтай”, “экологийн цэвэр”, “экологийн”, “био”, “биологийн”, “биологийн гаралтай”, “биологийн цэвэр”, гэсэн үгийг монгол болон гадаад хэлээр түүхий эд бүтээгдэхүүний шошгод байршуулах, хуулийн этгээдийн нэрээр баталгаажуулсан эсэх асуудлыг судлан шийдвэрлэх, хянах тогтолцоог хэрхэн бүрдүүлж байгаа талаарх мэдээлэл;

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангуулахаар Улсын бүртгэлийн газарт 02/1574, Гаалийн ерөнхий газарт 02/1575 дугаартай албан бичгээр тус тус албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна.

Цаашид Зар сурталчилгааны тухай хуульд органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тухай тусгах мөн олон нийтийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг идэвхижүүлэх шаардлагатай болно.

Асуулт 8: ХХААХҮЯ-ны дэргэд органик салбарын Үндэсний зөвлөлийн байгуулах, ХХААХҮ-ийн судалгаа хөгжлийн төвд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах, аймаг, нийслэлийн Засаг дарга органик үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөртэй байх асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар;

Органик салбарын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд салбарын төрийн бус байгууллагуудын оролцоог хангах талаар 02/1877 албан тоотыг хүргүүлэн ажиллаж байна. Ирсэн саналд үндэслэн тус зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлана.

Төсвийн хэмнэлтийн хүрээнд Судалгаа хөгжлийн төвд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгааны нэгж байгуулах санал хасагдсан хэдий ч мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэнүүдийн 2025 оны төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд органик үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгаа, мэдээлэл хийх талаар тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 02/1577, Боловсролын яаманд 02/1576 тус тус дугаартай албан тоотоор хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай чиглэл хүргүүлсэн байна.

Асуулт 9: Шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал, органик бордоо худалдан авсан эхний 3 жилийн зардлыг тус тус төрөөс санхүүжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байгаа эсэх, мөн сургуулийн хоол үйлдвэрлэлийн нэгж нь Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасны дагуу органик бүтээгдэхүүнийг хэрхэн хэрэглэж байгаа талаар;

Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын журмын төсөлд тусгагдсан.

Асуулт 10: Хүнсний тухай хууль болон хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн шинэчлэлт, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх талаар хийгдэж буй ажил, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;

Ж.ЭНХБАЯР